

МОНГОЛЫН СЭЦЭД МЭРГЭД БА “МЭТГЭЛЦЭХ СОЁЛ”

*Л.Оюунгэрэл**

XIII зуунд монголчуудын аман ярианы соёлын нийгэмд гүйцэтгэх үүрэг өндөр байжээ. Чингис хааны улс төр, цэргийн шийдвэрүүдийг “сэцдийн зөвлөлөөр” хэлэлцүүлж байсан нь эртний монголчуудын улс төрийн соёлын нэгэн өвөрмөц онцлог байв. Эх сурвалжуудад монголын сэцэд мэргэдийн талаар юу өгүүлсэн тухай авч үзэхэд Нууц Товчоонд Чингис хааны зарлиг шийдвэр буюу Монголын эзэнт гүрний албан ёсны бодлогын шинжтэй мэдээлэл давамгайлж байна. Харин Лувсанданзаны Алтан Товч монголын сэцэд мэргэд гэж хэн байсан, тэд асуудлыг чухам яаж хэлэлцэж байсан талаар сонирхолтой мэдээллийг агуулжээ.

Цэрэг байлдааны шийдвэрийг юуны өмнө Чингис хааны алтан ургийнхан, мөн Чингисийн есөн сайд-Хөлөг Боорчи, Гүшиний Борохул, Залайрын Мухулай, Татаарын Шихихутуг, Бэсүдийн Зэв, Урианхайн Зэлмэ, Сулдуртайн Торхан Шар, Ойралдын Хара Хирүгэ, Зөрчидийн Чуу Мэргэн гэсэн бүрэлдэхүүнтэй Сэцдийн зөвлөл гаргадаг байв. Сэцэд мэргэд юуны өмнө “Хан их төрийн юумайг зөвлөх”,¹ “сайн мууг ялган хэлэлцэх”² буюу зарга шүүх үүрэгтэй байжээ.

Мэтгэлцээний талаарх эртний монголчуудын ойлголтыг тодруулахад түүнийг илэрхийлж байсан үг хэллэгийг судлах явдал чухал юм. Сэц булаалдахын утга учрыг жишээлбэл “буруу үгийг сэлбэх”³ гэж ойлгож байжээ. Ердийн ярих – “үг өгүүлэх”, “үг айлгах”, “онож хэлэх”⁴-ээс гадна бас шүлэглэх, яруу тод хэлж ярихыг бас чухалчилж байсан нь “аялгуулж өгүүлэх”, “үг барилдах”, “үг чуулах”, “үг холбох”⁵ зэрэг нэр томъёо хэрэглэж байснаас харагдаж байна. Чингис хаан хошин шог яриаг үнэлдэг байсан нь түүний өнчин хөвгүүнд хандаж:

“Үгтэй болбол өчиж

Хошинтой болбол холбож

Гайгүй хэл”⁶ гэснээс харагдаж байна.

Сэцэд мэргэд үг холбохдоо хэрхэн хандаж байсныг Тангудайн Хуйлдар сэцний хэлсэн доорх үгнээс харж болно. Тэр:

Зуун үгийг өгүүлтэл

Янз нэгийг сахигтун

Түмэн үгийг өгүүлтэл

Төв нэгийг гаргагтун

*Л.Оюунгэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Түмэн үгийн төв нэгэн
Зуун үгийн янз нэгэн буй гэжээ.⁷

Монголын сэцэд мэргэд мэтгэлцэх аргыг: “үг тэмцэх”, “үгээ татах”, “үгээ цэнэх”, “үг ажиглах”, “үг булаах”⁸ зэргээр ойлгож байжээ. XIII зууны үеийн монголчуудын мэтгэлцээний гайхамшигт жишээ бол өнчин хөвгүүн, өсөн өрлөгтэй үг тэмцэж байгаа явдал юм. Эртний монголчууд “сэтгэлгээний чөлөөт байдлыг” хэрхэн ойлгож байсныг Чадана цэцэн байгаль дэлхийн үзэгдэлтэй зүйрлэн гайхамшигтай шүлэглэж тодорхойлсноос харж болно:

“Ховсор цэцэн чиний үгийг булаасан биш билээ.

Хувьд өөрийн санаагаа хэллээ би.

Буруу зөв хоёрыг ялгадаг үгүй буюу чи.

Буллинггар үгүй далайг өмчирхдөг буюу чи.

Хариу үгүй муу над лугаа үг тэмцдэг буюу

Онон мөрнийг ховоогоор ширгээдэг буюу

Огторгуйн солонгыг гараар барьдаг буюу

Эдэр мөрнийг элсээр боодог буюу чи

Эрдэмт сайн хүнийг санаагаар цэнэдэг буюу”⁹

Сэцдийн хурлыг Чингис хаан өөрөө удирдаж “үг тэмцсэний” эцэст голдуу ямар нэгэн зарлиг гаргадаг байжээ. Хэлэлцэж ярьж байсан зүйлийг хаан ихэд анхаарч байсан төдийгүй утга агуулгыг нь машид тунгаан бодож байсны нэг жишээг доорх ярианаас харж болно. Нэгэн өдөр Гоо сэцэн хаандаа: “Хөлөг сайдууд өтөлвөл хүний үг даган ажгуу” хэмээсэнд Чингис хаан маш зөвшөөн өгүүлэгтүн гэжээ.

Гоо сэцэн: Үгийн сайн тоо бөгөөтөл

Дуустал үл өгүүлнэ хэмээсэнд

Чингис зарлиг болгов: Үгийн дотрыг нь бүгд өгүүлэв

Бас өгүүлтэл үүнээс үгүй. (Үүнээс өөр юу өгүүлэх вэ?) гэсэн нь¹⁰ үгийн утга санааг ихэд анхаарч байсан гэлтэй.

Чингис хаан сэцдийн зөвлөлд ихээхэн эрх мэдэл өгч байсны нотолгоо бол “Өөрийн гэмийг бусдаас асууж мэд, Төр ёсны ослыг сэцдээс асууж сурагдахуй” гэсэн түүний зарлигаас харагдаж байна.¹¹

Дайн байлдааны үед гадаадын улс орны талаарх үнэ цэнэтэй мэдээллийг цэргийн жанжнууд Чингис хаан, Сэцдийн Зөвлөлд өгч улмаар шийдвэрүүдийг байлдааны явцад түргэн шуурхай гаргаж байжээ. Жишээлбэл Хорезмын аян дайны үеэр Чингис хаан Сүбээдэй, Зөв, Бала нарыг Өрнө, Дорно зүгт тагнан турших аянд мордуулж элчээр

дамжуулан байнга холбоотой байж зарлиг тушаалаа хүргүүлж байв. Мөн бичгийн хүмүүсээр Унгар, Польш, Силез, Богемын бүдүүвч газрын зургийг зуруулсан нь¹² тэдний тандалт, судалгаан дээр үндэслэсэн бололтой. Хорезмд олон хэлний хэлмэрч дайчлан нутагтаа аваачсан ба хожим эзэлсэн газар нутаг руу илгээх тагнуул, туршуулыг эзлэгдсэн улс орны хүмүүсээс дайчилж байжээ.

Чингис хааны жанжнууд дайн байлдааны ажиллагааны талаар эрх мэдэлтэй байж бие даан шийдвэр гаргадаг байв. Анх Хорезмын аян дайны үеэр Хонхор хорчи, Хорирун хорчи нар хаанд өчсөн нь: “Наран шингэхүйеэ ероолт хүртэл дайн иргэн буй. Манийг төвд одон түрж илгээвээс, тэнгэр газарт хүч нэмэгдэж, алтан мөнгөн агуурсан эд таваар, иргэн оргон чамд авчирсугай. Аль иргэнд явуулах вэ хэмээвээс Багдад иргэний Халиф султан хэмээх буй хэмээмүй гэсэнд Чингис хаан зарлиг гаргаж Үтэггэгийн Чормаганыг Багдад улсын Халиф султанд аялуулав” гэжээ.¹³ Энэ нь улс төрийн шийдвэрийг эцэд мэргэд, жанжнуудынхаа саналыг сонсож хэрхэн гаргаж байсныг харуулж буй сонин жишээ юм. Чингис хааны гаргасан эл шийдвэр Өрнөд Азийн улс орнуудын амьдралд олон зуун жилийн турш нөлөө үзүүлэх шийдвэр болсоныг бид түүхээс мэдэх билээ.

Чингис хааны үед ч, хожим түүнийг залгамжлагчдын үед ч гаднаас ирсэн мэдээллийг хэвтүүл хүлээн авдаг журам байжээ. Алтан Товч-д энэ талаар бичихдээ: “Яаралтай хэл хүргэж хүн ирвээс, хэвтүүлд хэлэлцэж (мэдэгдэж) гэрийн умраас хэвтүүл лүгээ хамт байж хэлүүлтүгэй гэж Чингис хаан зарлиг болгосон”¹⁴ гэжээ. Үүнээс харахад мэдээллийг анх хэвтүүл авч хаанд дамжуулж бас хааны гаргасан зарлиг, шийдвэрийг хамгийн түрүүнд сонсож дамжуулдаг байжээ. Тийм ч учраас хэвтүүлийг сургахад их анхаарч байсан бололтой. Хэвтүүлүүд ордны чэрбийн охид, гэрийн хөвгүүдэд “багшлах” үүрэгтэй байжээ.¹⁵ Тиймээс анх бичигтэн болсон хүмүүс хэвтүүлүүд гэж таамаглаж болмоор мэт.

Рашид ад-Дин “Судрын чуулганаа” бичихдээ монгол эх сурвалжуудыг ашигласан гэж тэмдэглээд зохиолоо яаж бичсэнээ бас өгүүлжээ. “Хааны айлдсан үг бүрийг өдөр дараалан тэмдэглэдэг заншилтай байсан. Хаад гол төлөв оновчтой битүү утгатай үг айлддаг учир бараа бологчдоосоо нэгэн хүнийг томилон айлдсанаа тэмдэглүүлдэг байсан” гэжээ.¹⁶ Чингис хааны үед ч ийм байсан тухай бид дээр тэмдэглэсэн билээ. Оросын эрдэмтэн Бартольдын судалснаар Цагаадай хааны үед түүний хэлсэн үгийг өдөр бүр тэмдэглэдэг заншилтай байсан бөгөөд хаан зүйр цэцэн үг хэлж уран илтгэдэг байжээ. Нэгэн найран

дээр Цагаадай, Өгэдэй хаад уран үгээр цэц булаалдаж өөр өөрсдийн сайд Везир, Чингай нарт тэмдэглэл хийхийг даалгаж хооронд нь уралдуулж¹⁷ байжээ.

Чингис хааны үед мэргэд сэцэд, жанжин баатрууд, хэвтүүл, элч, бичээч, хэлмэрч гээд Монголын эзэнт гүрний мэдээлэл солилцох, судлах, дамжуулах, мэтгэлцэх, сонгож авах гээд мэдээллийн бүхэл бүтэн тогтолцоо байжээ. Чухам энэ тогтолцоонд тулгуурлан Чингис хаан цэрэг, улс төрийн шийдвэрээ гаргаж хууль зарлиг болгож байв.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Лувсанданзан, Алтан Товч, УБ, 1990, х. 88
2. мөн тэнд, х. 86-87
3. мөн тэнд, х. 91
4. мөн тэнд, х. 91
5. мөн тэнд, х. 64-91
6. мөн тэнд, х. 89
7. мөн тэнд, х. 98
8. мөн тэнд, х. 105
9. мөн тэнд, х. 91
10. мөн тэнд
11. мөн тэнд, х. 82
12. James Chambers, The Devil's Horsemen, The Mongol Invasion of Europe, New York, 2003, p. 25
13. Лувсанданзан, Алтан Товч, УБ, 1990, х. 135-136
14. мөн тэнд, х. 94
15. мөн тэнд, х. 82-83
16. Рашид ад-Дин, сборник летописей, М, 1952, том 1, книга вторая, с. 205
17. В.В.Бартольд, Туркестан под владычеством монголов (1227-1269), Сочинения, том 1, М, 1963, с. 491